

СПОРТЫН НИЙГМИЙН АЖЛЫН ХӨГЖЛИЙН АСУУДАЛД

*Б. Мөнхнасан
Докторант*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль,
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

munkhnasan765@must.edu.mn

*Б. Бат-Өлзий
Доктор /Ph. D./*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль,
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

bbatulzii04@gmail.com

Хураангуй: Монгол улсад нийгмийн ажлын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж эхлээд 25 жил болж байна. Нийгмийн ажилтнууд нь нийгмийн сайн сайхны төлөөх нийгмийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд гар бие оролцохын зэрэгцээ боловсрол, эрүүл мэнд, хорих байгууллага, цагдаа, эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, залуучуудын гэх мэт төрийн болон олон нийтийн байгууллага, нийгмийн бүлгүүдтэй ажилладаг онцлогтой мэргэжил. Орчин үед нийгмийн ажилтнуудын анхаарлаа хандуулж, нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлж буй нэг чухал томоохон салбар бол яах аргагүй спорт, тэр дундаа тамирчид юм. Харин Монгол улсад спортын нийгмийн ажил хараахан хөгжөөгүй, энэ чиглэлд мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэгдэж эхлээгүй байдалтай байна. Тиймээс манай улсад спортын нийгмийн ажлыг хөгжүүлэх боломжийг эрэлхийлэхийн тулд олон улсын спортын нийгмийн ажлын үүсэл хөгжил, өнөөгийн нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр спортын нийгмийн ажилтны мэргэжлийн ур чадварыг тодорхойлох хэрэгцээ тулгарч байна.

Түлхүүр үгс: спорт, тамирчин, спортын нийгмийн ажил, спортын нийгмийн ажилтны ур чадвар

ҮНДСЭН ХЭСЭГ

Спортын нийгмийн ажлыг тодорхойлохын тулд түүний үүсэл хөгжил, орчин үеийн түүхийг товчхон дурьдах нь зүйтэй. Спортын нийгмийн ажлын анхны санаачлагууд Америкт анхлан хөндөгдөж, харьцангуй амжилттай хөгжиж байна.

Спортын нийгмийн ажлын үүсэл: *Нийгмийн ажлын анхдагч Жэйн Аддамс спортын нийгмийн ажилд тэргүүлэх үүргийг гүйцэтгэжээ. (Reynolds,*

2017). Жэйн Аддамс Европын цагаачдыг Америкийн соёлын ассимляцид²¹ орох үед эрүүл мэндэд тустай үйл ажиллагаанд оролцохыг дэмжих зорилгоор Халл Хаус нийгэмлэгийн төвд олон спортын хөтөлбөр, спортын тэмцээнийг ивээн тэтгэж байсныг нотлох баримт бий (Reynolds, 2017). Жэйн Аддамс 1889 онд Чикаго хотын Баруун хэсэгт орших дэлхийд алдартай Халл хаус хэмээх нийгмийн сууринг Эллен Гейтс Старртай хамтран байгуулжээ. (About Jane Addams and Hull-House Settlement, 2022). Жэйн Аддамсын эхэн үеийн энэхүү үйл хэрэг нь нийгмийн ажил, спорт хоёрын огтлолцлын цэг болсон гэж үзэж болно.

Жэйн Аддамсын эл үйл хэргээс гадна нийгмийн ажилтны анхаарлын төвд байдаг нийгмийн шударга бус байдалтай тэмцэхэд спорт нь хүчирхэг платформ болдог. 1945 оны 8-р сарын 28-нд Бранч Рики Жеки Робинсонтой гэрээ байгуулж бейсболын дээд лиг дэхь арьс өнгөний үзлийг эсэргүүцсэнээр түүхэнд бичигджээ. Уэсли Бранч Рики (1881-1965) нь бейсболын тамирчдыг сургах сургалтын системийг зохион байгуулж хөгжүүлсэн (1919), мөн хар арьст тоглогчдыг ажилд авсан 20-р зууны Америкийн мэргэжлийн бейсболын анхны менежер байсан. (Britannica, 2021). Үүний араас Рики мөн Испани гаралтай анхны супер од Роберто Клементетэй гэрээ байгуулсан. Энэ нь спорт нийгмийн шударга ёсыг сахиулах томоохон хүч болохыг баталж өгсөн төдийгүй спортын нийгмийн ажлын хөгжилд чухал нөлөө үзүүлжээ.

Улмаар Томми Смит, Жон Карлос, Мухаммед Али, Билли Жин Кинг, Меган Рапино, Колин Каеперник, Леброн Жэймс зэрэг тамирчид арьс өнгө, хүйс, бэлгийн амьдрал болон нийгмийн идэвхийн бусад элементүүдтэй холбоотой асуудлуудыг үргэлжлүүлэн хөндсөн. Шударга бус байдлыг зөвхөн тамирчид төдийгүй спортын багууд (Грэмблинг ба Миссуригийн их сургуулийн баг г.м.) болон мэргэжлийн лигүүд (жишээлбэл, NHL болон NBA) мөн арьс өнгө, тоглолтын ижил тэгш нөхцөл, ялгаварлалгүй цалин хөлсний асуудлаар эсэргүүцсэн түүхтэй. (Moore, M. A., & Gummelt, G., 2018, хууд. preface 14)

Спортын нийгмийн ажлын хөгжлийн орчин үе: Америкийн нийгмийн ажлын багш нар болон дадлагажигчид, оюутнууд, өмгөөлөгчидөөс бүрдсэн хэсэг хүмүүс сүүлийн хэдэн жилийн хугацаанд нийгмийн ажлыг спортын бүх салбарт нэвтрүүлэхийн тулд асар их хүчин чармайлт гаргажээ (Matthew Moore, Sasa E. Vann, Kelsey Freiburger, Hannah Johnson, 2019, January 22). Энэхүү хүчин чармайлтын гол үр дүн нь Спортын Нийгмийн Ажилтны Холбоо (ASWIS) байгуулагдсан явдал мөн. Америкийн спортын нийгмийн

²¹assimilation /əˈsɪmɪˈleɪʃ(ə)n/ буюу уусгах гэдэг нь антропологи, социологийн шинжлэх ухаанд өөр өөр угсаатны гарал үүсэлтэй хувь хүн эсвэл бүлгүүдийг нийгмийн давамгайлсан соёлд шингээх үйл явц юм. (Pauls, Elizabeth Prine, 2019)

ажилтны холбоо нь 2015 онд байгуулагдсан ба нийгмийн ажил нь спортын бүх түвшин, бүх сегменттэй хэрхэн түншлэх, ямар хувь нэмэр оруулж болох арга замуудыг эрэлхийлдэг (Moore, 2022). Энэхүү байгууллага нь тамирчдын ерөнхий хөгжил болон зан үйлийн эрүүл мэнд, нийгмийн сэтгэлзүйн хэрэгцээг шийдвэрлэхэд нийгмийн ажилтнуудын өвөрмөц ур чадварыг ашигладаг олон улсын цорын ганц нийгмийн ажлын холбоо юм. Холбоо нь спортын нийгмийн ажлыг макро түвшинд сурталчлах бодлого барьж, энэ чиглэлийн судалгааны салбарыг хөгжүүлэхэд анхаарч ажилладаг.

Одоогийн ерөнхийлөгч бөгөөд Спортын Нийгмийн Ажилтны Холбооны үүсгэн байгуулагч Мэтт Мур хэлэхдээ “нийгмийн ажилтнууд нь тамирчид болон спортын соёлд юу авчрах вэ? гэдэг дээр бусад байгууллага, тэдний удирдлагуудыг гүн гүнзгий, өргөн далайцтай ухуулан сурталчлахад хамтын дуу хоолойгоо хүргэх шаардлагатай” байгааг онцолсон. Тэрээр цааш нь нийгмийн ажилтнууд тамирчдын аюулгүй байдал, сайн сайхан байдлыг²² дэмжих, эрх ашгийг хамгаалах, дэлхийн хэмжээнд хүрч өсөж дэвшихэд нь дэмжлэг үзүүлэх, тэднийг хүлээн зөвшөөрөх мэргэжлийн сүлжээг бий болгох хэрэгцээтэй байгааг онцолсон байна. Мөн тамирчдын эрүүл мэнд, хөгжлийг дэмжих шилдэг туршлага, шинэлэг арга барилын талаар байнгын судалгаа явуулах, боловсрол олгох хэрэгтэй гэжээ.

Спортын нийгмийн ажлыг тодорхойлох нь: "Нийгмийн ажил мэргэжлийн гол зорилго нь хүний сайн сайхан байдлыг дээшлүүлж, хүмүүсийн суурь хэрэгцээг хангахад туслах бөгөөд эмзэг бүлгийнхний хэрэгцээ, эрх мэдлийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулах явдал юм" гэж Нийгмийн Ажилтны Үндэсний Холбоо [NASW, 2017] тодорхойлсон байдаг. Энэ тодорхойлолтонд анхаарах хэсэг бий. Спортын нийгмийн ажилд "эмзэг" гэсэн үг сонирхол татна, учир нь нийгмийн олонхи нь тамирчдыг эмзэг бүлэгт хамааруулж үзэж болно гэсэн ойлголтыг эсэргүүцдэг. Харин ч тэднийг онцгой хүч чадал, нөөц бололцоотой, нийт хүн амд байдаггүй бусад онцлог шинж чанар, давуу талтай гэж хүмүүс хардаг. (Matt Moore, 2020) Тэгвэл спортын нийгмийн ажилтнуудад тулгарч буй гол асуудал бол тамирчид нийгмийн ажилтны тусламжийг хүртэх ёстой зорилтот бүлгийнхэн болохыг харуулах явдал юм. Хэрэв та хүмүүсээс “*Та тамирчдыг эмзэг бүлгийнх гэж боддог уу*” гэж асуувал “*үгүй*” гэсэн харилт авах магадлал өндөр юм.

Нийгмийн хувьд тамирчдад тулгарч буй бэрхшээлийг олж харахаасаа илүүтэйгээр өнгөц сайн сайхнаар дүгнэх хандлага давамгайл байдаг. Тамирчин

²² *wellbeing* /wel'bi:ni/ буюу сайн сайхан байдал гэдэг нь эрүүл, аз жаргалтай байдлын мэдрэмж. Жишээлбэл, игоор хичээллэж буй хүмүүсийн сайн сайхан байдлын мэдрэмж нэмэгддэг. (Cambridge)

Зарим тохиолдолд хамгаалал гэсэн утгаар хэрэглэнэ. (зох.ч)

болгон амжилт гаргаж, сайхан байдалд хүрдэггүй. Амжилттай яваа тамирчинд ч туламдсан асуудал тохиох нь бишгүй. Тамирчдад шударга бус хандахаас эхлээд тэдний аж амьдрал, нийгмийн харилцаанд олон олон бэрхшээл, зөрчлүүд бусдын адил тулгамдсан асуудал болон гарч ирдэг. Эдгээр эмзэг байдлыг шийдвэрлэхийн тулд спортын нийгмийн ажил хэмээх нийгмийн ажлын дэд салбар үүссэн. Спортын нийгмийн ажил дараах үйл ажиллагааг явуулдаг.

Үүнд:

- Спортын нийгмийн ажил нь хувь хүний болон хүрээлэн буй орчны түвшинд тамирчдын өвөрмөц хэрэгцээнд анхаарлаа хандуулснаар нийгмийн шударга ёс, өөрчлөлтийг дэмждэг,
- Спортын нийгмийн ажилтнууд олон нийтэд нөлөөлөх, зохион байгуулах, бодлого боловсруулах, боловсрол олгох, судалгаа шинжилгээ, байнгын дадлага хийх зэргээр тамирчдын эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжин ажилладаг,
- Спортын нийгмийн ажилтнууд тамирчдад зан үйлийн эрүүл мэнд, нийгмийн сэтгэл зүйн хэрэгцээгээ хангах чадварыг нэмэгдүүлэхийг эрмэлздэг,
- Тэд тамирчдыг өөрчлөлтийг дэмжихийг уриалдаг,
- Тэд мөн тамирчдыг эмзэг бүлгийнх гэж хүлээн зөвшөөрч, спортод тулгарч буй сорилт, бэрхшээлийг багасгахын төлөө нэгдэхийг спортын ба бусад байгууллага, олон нийтэд хандан уриалдаг.

Эдгээр хүчин чармайлтын гол үр дүн нь тамирчны хөгжил, эрүүл мэндэд анхаарал хандуулах явдал юм. Ингэхдээ нийгмийн ажилтан нь нийгмийн ажилтны мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн үнэт зүйл, ёс зүйг дагаж мөрддөг. (Moore, M. A., & Gummelt, G., 2018, хууд. 1) Мэтт Мур: *“Спорт нь ихэвчлэн хувь хүний хөгжил, зан чанар, тэсвэр тэвчээрийг сайжруулахад чиглэгддэг хэдий ч сүүлийн жилүүдэд тамирчдын зан үйлийн эрүүл мэндийн эрсдэл, нийгмийн сэтгэлзүйн эрсдэл, тамирчдад шударга бусаар хандах, тамирчдын нийгмийн идэвхи сэргэх зэрэг асуудлууд нэмэгдэж байгаа нь нийгмийн ажилтнуудын анхаарлыг татаж байна”* хэмээн тэмдэглэсэн (Moore, M. A., & Gummelt, G., 2018, p. preface XVI). Нийгмийн ажилтнууд тамирчдыг хамгаалахын тулд онол, практик, судалгаа, улс төрийн нөлөө, түншүүд зэрэг давуу талуудаа ашиглах хэрэгтэй гэж Мэтт Мур үзсэн. Түншүүдийн тухайд тэдний ихэнх нь тамирчдад маш сайн анхаарал халамж тавьж ирсэн олон жилийн мэргэжлийн баялаг түүхэн туршлагатай.

Нийгмийн ажил мэргэжил нь спортын салбарт олон талт, уян хатан харилцаа холбоог бий болгосоор байгаа тул бид дээрх мэргэжилтнүүдийн туршлагаас суралцаж, мэргэжлийн хоорондын хамтын ажиллагаагаар

дамжуулан спортыг дэмжихэд ашиглах боломжтой ур чадвараа хуваалцахыг хичээх ёстой.

Спортын нийгмийн ажлын ур чадварууд: Нийгмийн ажлын мэргэжлийн онол, практик, бодлого, судалгаанд үндэслэсэн гаргасан нийгмийн ажлын есөн ур чадвар байдаг. Америкийн Нийгмийн ажлын боловсролын зөвлөл нь нийгмийн ажилтнуудад "хувь хүн ба нийгмийн сайн сайхан байдлыг дэмжихийн тулд мэдлэг, үнэ цэнэ, ур чадвараа микро болон макро орчин нөхцөлд зорилготой, тооцоотой, мэргэжлийн арга барилыг хослуулан хэрэгжүүлэх чадвар"-ыг олгодог. ((CSWE), 2015, р. 6)

Спортын шинжлэх ухааны үүднээс авч үзвэл эдгээр чадварууд нь тамирчдад шударга бус хандахыг эсэргүүцэхэд шаардлагатай авьяас чадварыг нийгмийн ажилтнуудад олгохын зэрэгцээ тамирчдыг спортын орчинд болон түүгээр хичээлэдэггүй бусад хүмүүст хүчтэй нөлөөлөгчид болоход нь тусалдаг.

Судлаач доктор, Спортын нийгмийн ажилтны холбооны тэргүүн Мэтт Мур, судлаач доктор Жинжер Гаммелт нар Нийгмийн ажлын боловсролын зөвлөлөөс баталсан нийгмийн ажилтны ур чадваруудыг спортын нийгмийн ажилтай нийцүүлсэн.

Хүснэгт 1. Спортын нийгмийн ажлын ур чадвар

НАБЗ-ийн олгох ур чадвар	Спортын нийгмийн ажлын хөгжил
1. Мэргэжлийн болон ёс зүйн зан чанарыг харуулах	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн ажлын мэргэжлийн үндсэн үнэт зүйлс, ёс зүйн хэм хэмжээг сахих • Тамирчдын эмчилгээтэй холбоотой хэрэгжүүлж буй өнөөгийн бодлого, зохицуулалтын талаар ойлголттой болох • Тамирчдын хувийн намтарт шүүмжлэлт сэтгэлгээний зарчмыг хэрэглэх • Тамирчны талаарх хувийн санаа бодол мэргэжлийн дүгнэлтэнд хэрхэн нөлөөлж болохыг анхаарах • Тамирчдын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал /сайн сайхан байдал/-ыг дэмжихэд бусад мэргэжлийн гүйцэтгэх үүргийг мэдэх
2. Практикт олон талт байдал, ялгааг бий болгох	<ul style="list-style-type: none"> • Хувь хүний онцлог, олон янз байдал нь тамирчны туршлага, өвөрмөц шинж чанарыг хэрхэн бүрдүүлдэгийг ойлгох • Тамирчдад шударга бусаар хандахыг эсэргүүцэх тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгаалалд эерэгээр нөлөөлж буй спортын оролцоог хүлээн зөвшөөрөх • Тамирчдын био-психо-социаль²³ хөгжилд спортын соёл ямар үүрэг гүйцэтгэдэг болохыг ухамсарлах

²³ Био-психо-социаль загварыг анх 1977 онд Жорж Энгел санаачилсан бөгөөд хүний эрүүл мэндийн байдлыг ойлгохын тулд зөвхөн биологийн хүчин зүйлээр зогсохгүй сэтгэл зүйн болон нийгмийн хүчин зүйлсийг харгалзах шаардлагатай гэж үзсэн.

- Био (физиологийн эмгэг)

3. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчны шударга ёсыг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> • Тамирчдын зан үйлийн эрүүл мэнд, нийгмийн сэтгэлзүйн эрсдэлд өртөмтгий болгодог үндсэн бэрхшээлийг арилгах стратегийг судлах • Бүх тамирчдад нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдах боломжийг тэгш олгох
4. Практикт суурилсан судалгаа, судалгаа шинжилгээний мэдээлэлд суурилсан практикт хамрагдах	<ul style="list-style-type: none"> • Судалгааны аргуудын тусламжтайгаар тамирчдын нийгмийн хамгааллын талаарх ойлголт, мэдлэгээ баяжуулах • Тамирчдад үзүүлэх үйлчилгээг үнэлэх, сайжруулахад чиглэсэн судалгаа шинжилгээ хийх замаар спортын нийгмийн ажлын хөгжлийг дэмжих.
5. Бодлогын практикт оролцох	<ul style="list-style-type: none"> • Засгийн газар, байгууллагын түвшинд тамирчдын сайн сайхныг дэмжих бодлогыг сурталчлах • Коллеж, мэргэжлийн спортын үүсэл хөгжлийн түүхэн замнал нь өнөөгийн байдалд хэрхэн нөлөөлж байгааг ойлгох • Спортын өнөөгийн байдал тамирчдад микро, меззо, эпсо, макро түвшинд хэрхэн нөлөөлж байгааг судлах • Тамирчдын нийгмийн хамгаалалд чиглэсэн бодлогод нөлөөлж буй нийгэм, соёл, эдийн засаг, зохион байгуулалт, хүрээлэн буй орчны хүчин зүйлсийг тодорхойлох
6. Хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийттэй харилцах	<ul style="list-style-type: none"> • Тамирчдыг тэдний нийгмийн хамгааллын талаарх хэлэлцүүлэгт татан оролцуулах тогтолцоог бүрдүүлэх хүний зан үйл, нийгмийн орчны онолууд хэрхэн үүсдгийг ойлгох • Тамирчидтай “итгэлцэл”-д суурилсан харилцааг бий болгохын тулд “эрч хүч”-нд суурилсан хандлагыг ашиглах • Тамирчны нийгмийн хамгааллыг бататгахын тулд мэргэжил хоорондын холбоо харилцаа, хамтын ажиллагааг бий болгох зарчмуудыг эрхэмлэх
7. Хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, хамт олныг үнэлэх	<ul style="list-style-type: none"> • Тамирчдын давуу сул тал, хэрэгцээг үнэлэх • Тамирчдын өөрчлөлт хийх сэдлийг үнэлэх • Тамирчдад нөлөөлөх интервенцийн зорилгыг боловсруулж, эдгээр зорилгод хүрэхэд шаардлагатай алхмуудыг зохион байгуулах • Тухайн тамирчны хүсэл сонирхол, нийгмийн ажил мэргэжлийн үнэт зүйл, судалгааны баримт, мэдээлэл, үнэлгээнд тулгуурлан нөлөөлөх интервенцийн стратегээс аль тохирохыг сонгох
8. Хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийтийг зуучлах	<ul style="list-style-type: none"> • Тамирчдын гүйцэтгэлийг сайжруулах зорилготой сургалтанд нийцэх интервенцийг хэрэгжүүлэх • Тамирчдад ашигтай дадлага, туршлагыг бий болгохын тулд мэргэжлийн хоорондын хамтын ажиллагааг ашиглах • Тамирчдын шилжилтийг үр дүнтэй болгох

-
- *Психо (сэтгэл зүйн хямрал, айдас/зайлсхийх итгэл үнэмшил, одоогийн даван туулах арга, хамаарал зэрэг сэтгэл хөдлөл, зан үйл)*
 - *Социаль (ажлын асуудал, гэр бүлийн нөхцөл байдал, ашиг тус/эдийн засаг г.м. нийгэм-эдийн засаг, нийгэм-соёлын хүчин зүйлүүд)*

<p>9. Хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийттэй хамтран тэдний дадлага, туршлагыг үнэлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Спортын нийгмийн ажлын үр нөлөөг зан үйлийн эрүүл мэнд, сэтгэлзүйн болон өрсөлдөх чадвараар үнэлэх • Микро, меззо, ексо, макро түвшинд дадлага, туршлагын үр нөлөөг сайжруулахын тулд үнэлгээний үр дүнг ашиглах • Нийгмийн ажилтны мэргэжлийн үнэ цэнэ, үнэлгээ, судалгааны мэдлэг туршлага болон тухайн тамирчны хүсэл сонирхолд тулгуурлан зохих интервенцийн стратегийг сонгох
--	--

Эх сурвалж: Нийгмийн ажлын боловсрол олгох зөвлөлөөс (2015) Боловсролын бодлого, магадлан итгэмжлэлийн стандартад нийцүүлэн оруулсан болно. (Moore, M. A., & Gummelt, G., 2018, хууд. 3)

Монголд спортын нийгмийн ажил байсан уу? XX зууны эхэн үед Америкт Жейн Адамс тэргүүтэй нийгмийн ажлын анхдагчид Халл Хаус нийгэмлэгийн төвд олон спортын хөтөлбөр, спортын тэмцээнийг ивээн тэтгэж цагаач иргэд, олон нийтийг идэвхтэй дасгал хөдөлгөөн, биеийн тамирт уриалж байсан бол тухайн үеийн Монгол улсад төр засгийн бодлого шийдвэрээр бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилготой спортын хөдөлгөөнийг орон даяар өрнүүлж байжээ.

Судлаач эрдэмтэн Г.Цэрэндорж “1936 онд <<Улс орон ба аж үйлдвэрийг батлан хамгаалахад бэлхэн>> тэмдгийн норм батлагдсан явдал нь манай оронд биеийн тамир, спортыг нэгдсэн системтэй хөгжүүлэхийн үндэс суурийг тавьж өгсөн юм. Анхны тэмдгийн нормыг 1936 оны 6 сарын 9-нд ардын биеийн тамирыг удирдах зөвлөлөөс боловсруулан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд оруулж батлуулсан билээ” хэмээжээ. Тэрээр цааш нь “Энэ норм нь сурагчдын бие махбодыг чийрэгжүүлэн, тэдэнд хөдөлгөөний элдэв чадварыг олгох явдалд чухал үр дүнг өгч байсан учир энэ нормыг 1945, 1951, 1953, 1960, 1962, 1968, 1974 онуудад удаа дараа өөрчлөн <<Хөдөлмөр батлах хамгаалахад бэлхэн>> гэдэг нэртэй насны үндсэн ялгавраар биелүүлэх албан ёсны норм болтлоо өргөжин хөгжиж ирсэн” тухай тэмдэглэсэн байдаг. (Г.Цэрэндорж, 1988, хууд. 11)

Монголын биеийн тамир, спортын эвлэлийн байгууллага, намын их хурлын дэвшүүлсэн түүхэн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хөдөөгийн залуучуудын болон, пионер сурагчдын, бүх ард түмний спартакиадуудыг зохион байгуулж явуулсан нь биеийн тамир, спортын нийтийг хамарсан хөдөлгөөнийг өрнүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан байна. Үүний үр дүнд нийт спартакиадуудад 40 шахам мянган тамирчид оролцож үүнээс 5 мянга гаруй тамирчид спортын зэрэг шинээр биелүүлэх буюу ахиулж, 20 мянган хүн ХБХБ тэмдгийн нормыг биелүүлж, спортын материаллаг баазыг бэхжүүлэх талаар тодорхой үр дүнд хүрсэн байна. (Г.Цэрэндорж, 1988, хууд. 17)

1974 онд баталсан БНМАУ-ын Хөдөлмөр батлан хамгаалахад бэлхэн (ХБХБ) тэмдгийн иж бүрэн нормын гол зорилго агуулга нь:

- БНМАУ-ын <<ХБХБ>> тэмдгийн иж бүрэн норм нь хүн амын бие бялдрын хүмүүжлийн үндсэн хөтөлбөр бөгөөд тэднийг бие бялдар, оюун санаа, зан суртахууны өв тэгш хүмүүжилтэй болгох, эрүүл чийрэг, үр бүтээлч хөдөлмөрлөж эх орноо батлан хамгаалах үйлст бэлтгэх,
- ХБХБ тэмдгийн норм нь хүмүүсийн эрүүл мэндийг бэхжүүлж, хөдөлгөөний дадлага чадвар олгох спорт-хүмүүжлийн зорилтыг шийдвэрлэж, биеийн тамир, спортыг тэдний өдөр тутмын амьдралд нэвтрүүлэх, үндэсний болон дэлхий нийтийн спортын төрлөөр тогтмол хичээллүүлж, спортын авъяастнуудыг сурган хүмүүжүүлэхэд чиглэх.
- БНМАУ-ын ХБХБ тэмдгийн иж бүрэн норм нь өсвөр үе (бэлтгэл үе, I, II, III шат), насанд хүрэгчдийн (IV, V шат) хэсгээс бүрдэх бөгөөд 7-60 насны хүмүүсийг бүрэн хамрах. (Г.Цэрэндорж, 1988, хууд. 34)

ХБХБ тэмдгийн норм нь бүх нийтийн эрүүл мэндийг бэхжүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, өв тэгш спортын хүмүүжил, соёлтой иргэдийг төлөвшүүлэх, хүн амын өсөлт, улмаар нийгмийн хөгжилд чухал үр нөлөө үзүүлсэн.

Түүнчлэн МАХН-ын XV их хурал <<...Спортын болон залуучууд, үйлдвэрчний эвлэлийн зэрэг байгууллага биеийн тамир, спортын хөдөлгөөнийг хөдөлмөрчид ялангуяа залуучууд дотор сайн өрнүүлж, улам олон хүнийг хамран аж ахуйн хамт олны амьдралд үйлдвэрийн гимнастикийг өргөн нэвтрүүлж, спортын зарим төрлөөр дэлхийн хэмжээнд хүрэхийн тулд тамирчдын уран чадварыг байнга дээшлүүлэх хүмүүжүүлэх ажлаа байнга дээшлүүлэх хэрэгтэй>> гэж заасан²⁴ байна.

Энэ дагуу аймаг, хот, районы биеийн тамир, спортын хороодын ажлын гол талбар нь үйлдвэр, аж ахуй, соёл, боловсролын байгууллагын дэргэдэх биеийн тамир, спортын хамтлаг болсон. Спорт хамтлагын ажлын төлөвлөгөөнд:

- Зохион байгуулалтын ажил
- Спортын сургалт хүмүүжлийн ажил
- Нийтийг хамарсан биеийн тамир, эрүүлжилтийн арга хэмжээ
- Идэвхтэн нартай ажиллах арга хэмжээ
- Улс төр, хүмүүжлийн ажил
- Сурталчилгааны ажил
- Эмнэлэг үйлчилгээний ажил
- Материал хангамж, аж ахуйн ажил гэх зэрэг багтана. (Г.Цэрэндорж, 1988, хууд. 106)

²⁴ МБТСЭ-ийн анхдугаар их хурлын материал. УБ., УХГ. 1961

Дээрх ажлын төлөвлөгөөнд зохион байгуулах, сургалт, сурталчилгаа, нөлөөлөл, төрийн байгууллагуудтай холбогдох зэрэг орчин үеийн спортын нийгмийн ажилтнуудын хийж гүйцэтгэж буй цөөнгүй үүрэг өөр нэршил, хэлбэртэйгээр тусгагдсан байгааг харж болно. Мөн судлаач Г.Цэрэндоржийн дурьдсанчлан ...аймаг, хот, районы биеийн тамир, спорт хороодын жилийн үндсэн төлөвлөгөөний дагуу спортын төрлүүдийг хариуцсан дасгалжуулагчид сургалтын хэтийн төлөвлөгөөг хийдэг. Хэтийн төлөвлөлтийн 8-р зүйлд сургууль, гэр бүл, олон нийтийн байгууллагуудын хоорондын холбоо, 9-р зүйлд сургуулийн сурган хүмүүжүүлэх хамт олны оролцоо гэх мэт асуудлууд багтсаныг спортын нийгмийн ажлын чиг үүрэгт хамааруулан авч үзэх боломжтой. Энэ бүхнээс харахад тухайн үед спортын нийгмийн ажилтан гэж мэргэжилтэн, тийм орон тоо байгаагүй ч ажлын байрны хэрэгцээ шаардлага бодиттойгоор тулгарсныг өөрийн гэсэн арга замаар зохицуулж байсан байна.

Манай улсад орчин цагийн биеийн тамир, спорт болон нийгмийн ажил мэргэжлийн үүсч хөгжсөн түүхийг судлахад спортын нийгмийн ажлын талаарх мэдээ, баримт хомс байна. Энэ нь спортын холбоо, нийгэмлэг, хамтлаг, мэргэжилтнүүдийн ажил үүрэгт нийгмийн ажилтны хийх ажил хавсрага болж байсантай холбоотой.

Манай улс зах зээлийн нийгэмд шилжсэн 1990 ээд оны эхэн үед олон салбарт төрийн анхаарал суларч, орхигдсоны нэг нь биеийн тамир, спортын салбар байсан. Түүнийгээ дагаад энэ үед спортоор хичээллэгчид, тамирчдын нийгмийн асуудлууд ч бүхэлдээ орхигдсон юм.

Орчин үед тамирчдын нийгмийн асуудалд анхаарч, нийгэмд илүү үр нөлөөтэй, зөв үлгэр дууриалтай амьдрахад спортын нийгмийн ажлын хэрэгцээ шаардлага зүй ёсоор урган гарч ирж байна. Спортын нийгэмд гүйцэтгэх үүргийг спортын нийгмийн ажилтнууд улам бүр тодруулж улмаар тамирчдад тулгардаг нийгмийн асуудлууд төдийгүй, нийтийн биеийн тамир, спортын хөгжилд ихээхэн түлхэц үзүүлэх бүрэн боломжтой байна.

Монголд спортын нийгмийн ажлыг хөгжүүлэх хэрэгцээ. Уг хэрэгцээг тодорхойлсон судалгаа шинжилгээний дорвитой ажил өнөөдөртөө Монголд хийгдээгүй байна. Гэвч спортын нийгмийн ажлын дэлхий нийтийн хөгжлийн хандлагыг харсан ч, Монголын спортын салбарын өнөөгийн төлөв байдал хийгээд цаашдын хөгжлийг бодолцсон ч спортын нийгмийн ажлыг Монголд нэвтрүүлж хөгжүүлэх шаардлага, хэрэгцээ зайлшгүй байна.

Манай улсад 1990 оноос хойш спортын салбар чөлөөт нийгмийн зарчмаар өндөр хөгжилтэй барууны орнуудын жишгийн дагуу хөгжих эхлэл тавигдсан билээ. Гэвч барууны жишигт хүрэхэд зай хол, бэрхшээл их тулгарч байна. Барууны жишиг нь өөрөө төгс загвар биш боловч олон зуун жилийн түүхэн хөгжил, алдаа оноо, туршлага, шинжлэх ухааны судалгааны үр дүн

төдийгүй, хууль эрх зүйгээс эхлээд санхүү мөнгө, тамирчдын эрүүл мэнд, амьдарлын баталгаа, нийгмийн хамгааллын цогц дэмжлэг бүхий систем юм. Өнөөдөр Монголын спортын салбар төр, хувийн хэвшлийн багахан дэмжлэг, унаган спортын авъяас бүхий тамирчдынхаа хүчээр аажим урагшилж байна. Мэргэжлийн спортын бие даасан холбоодууд байгуулагдаж, төр, спортод элэгтэй хувийн хэвшил тодорхой хэмжээнд дэмжиж санхүүжилт олгож, зарим спортын төрлүүдээр тив, дэлхий, олон улс, олимпод амжилтууд гаргаж байгаа ч тамирчдын сэтгэл зүй, эрүүл мэнд, амьдарлын баталгаа, цалин орлого, нийгмийн хамгааллын асуудлууд орхигдсон хэвээр байна.

Спортын салбарын цаашдын хөгжилд, нэн ялангуяа тамирчдын амжилтанд тэдний нийгмийн тулгамдсан асуудал шууд хамааралтай нөлөө үзүүлдэг. Аливаа хүний амьдралд тохиолддог бүхий л зовлон бэрхшээл тамирчдад ч мөн адил тулгардаг. Магад олны нүдэнд ил байдаг, нэр хүндтэй “од” тамирчдын хувьд энэ нь бүүр ч илүү эмзэг асуудал болж хувирдаг. Гэр бүлийн дотоод асуудал, орон байр, үр хүүхдүүдийн сурлага хүмүүжил, хань ижилтэйгээ үл ойлголцох, гэр бүл салалт, архи тамхи, мансуурах дон, нийгмийн харилцааны бэрхшээл, хэт өндөр алдар хүндэд хүрэх, алдар хүндээ алдах, бусдад ад шоо болох, сошиал хүчирхийлэлд өртөх, хүний эрхийн зөрчил, ёс зүйн зөрчил, эрүүл мэндийн доройтол, гэмтэл бэртлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болох, орлогын хомсдол, амьжиргааны доройтол, карьер өсөлт ба уруудалт гээд олон асуудлууд тамирчдын өмнө тулгардаг. Энэ бүхнийг даван туулахад туслах мэргэжилтэн бол спортын нийгмийн ажилтан юм. Гэтэл өнөөдөр манай тамирчид энэ бүх тулгамдсан асуудлуудаа өөрсдийн хүчээр даван туулах оролдлого хийж байгаа ба хичнээн тамирчин энэ бүхний өмнө хүчин мөхөстөнийг ч тодорхой хэлэх боломжгүй байна. Түүнчлэн спортын нийгмийн ажил нь зөвхөн тамирчинд туслаад зогсохгүй спортын салбарт шударга ёс, хүний эрхийг дээдлэх зарчмыг дэлгэрүүлэх ач холбогдолтой билээ.

ДҮГНЭЛТ

Спортын нийгмийн ажил баруунд, тэр тусмаа Америкт тодорхой түвшин хөгжиж байгаа салбар юм. Энэ чиглэлийн мэргэжлийн холбоо байгуулагдаж, бодлогын түвшингээс эхлээд практик түвшинд тамирчдад нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх гэх мэтээр өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол улсын хувьд социализмын он жилүүдэд спортын нийгмийн ажилтны ажил үүргийг багийн болон хувь дасгалжуулагч, спортын зааварчлагч, спортын хамтлаг болон холбоо, нийгэмлэгийн ажилтнууд ажил үүргийн хүрээнд хавсрага байдалтай шийдвэрлэж ирсэн байна. Ардчилал, зах

зээлийн нийгмийн шилжилтийн хямралын он жилүүдэд спортын салбар, тамирчдын нийгмийн асуудлууд анхаарлын гадна хаягдан үлдсэн билээ. Тиймээс өнөөдөр монголд спортын нийгмийн ажлын салбарыг хөгжүүлэх нийгмийн бодит хэрэгцээ шаардлага үүссэн гарч байгаа юм. Нэн түрүүнд Мэтт Мур, Жинжер Гаммелт тэргүүтэй спортын нийгмийн ажилтай холбоотой олон улсын судалгаа шинжилгээний ажил хийж буй олон эрдэмтэн судлаачдын бүтээл, туршлагатай танилцах, монгол хэлэнд орчуулж олон нийтийн хүртээл болгох, нэгдсэн ойлголт мэдлэгтэй болох нь чухал. Улмаар спортын салбар дахь тамирчдын бодит нөхцөл байдал, нийгмийн асуудлуудын талаар судалгаа шинжилгээний ажил хийж, бусад орнуудын спортын нийгмийн ажилтнуудыг бэлтгэх тогтолцоо, мэргэжлийн ур чадвар, мэдлэг туршлагыг харьцуулан судлах хэрэгтэй.

НОМ ЗҮЙ

- [1] (CSWE), C. o. (2015, June 11). *Educational Policy and Accreditation Standards*. Retrieved from www.cswe.org: https://www.cswe.org/getattachment/Accreditation/Accreditation-Process/2015-EPAS/2015EPAS_Web_FINAL.pdf.aspx
- [2] *About Jane Addams and Hull-House Settlement*. (2022, January 31). Retrieved from hullhousemuseum.org: <https://www.hullhousemuseum.org/about-jane-addams>.
- [3] *Britannica*, T. E. (2021, December 16). *Branch Rickey*. Retrieved from britannica.com: <https://www.britannica.com/biography/Branch-Rickey>.
- [4] Gatchel, R. J., Peng, Y. B., Peters, M. L., Fuchs, P. N., & Turk, D. C. (2007, January 1). *The biopsychosocial approach to chronic pain: Scientific advances and future directions*. *Psychological Bulletin*, 582. doi:<https://doi.org/10.1037/0033-2909.133.4.581>
- [5] Matt Moore, M. P. (2020, July 20). *Social Work: Introduction to Sport Social Work*. Retrieved from continued.com: <https://www.continued.com/social-work/articles/introduction-to-sport-social-work-38>
- [6] Matthew Moore, Sasa E. Vann, Kelsey Freiburger, Hannah Johnson. (2019, January 22). *The end is not the injury: Posttraumatic growth after season- or career-ending injuries*. *Journal of Amateur Sport*, 87-102.
- [7] Moore, M. (2022, February 3). *Alliance of Social Workers in Sports*. Retrieved from www.aswis.org: <https://www.aswis.org/history>
- [8] Moore, M. A., & Gummelt, G. (2018). *Sport Social Work: Promoting the Functioning and Well-being of College and Professional Athletes*. San Diego, CA:: Cognella Academic Publishing; 1st edition.
- [9] Moore, M. A., & Gummelt, G. (2018). *Sport Social Work: Promoting the Functioning and Well-being of College and Professional Athletes*. San Diego, CA:: Cognella Academic Publishing; 1st edition.
- [10] Reynolds, J. F. (2017). *Jane Addams' forgotten legacy: Recreation and sport*. *Journal of Issues in Intercollegiate Athletics, Special Issue*, 11-18.
- [11] Г.Цэрэндорж. (1988). БНМАУ-ын биеийн тамирын зохион байгуулалтын зарим асуудал. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- [12] *Нийгмийн ухааны салбар*. (n.d.). Retrieved February 27, 2022, from ШУТИС. Бизнесийн Удирдлага, Хүмүүнлэгийн Сургууль: <http://www.sbh.edu.mn/mn/index.php/content/sub/51>